

□
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар А/677

Улаанбаатар хот

ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Байгалийн ургамлын тухай хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7^{1.2} дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.Нэн ховор, ховор, зарим элбэг ургамлын экологи эдийн засгийн үнэлгээг хавсралт ёсоор баталсугай
- 2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар /Д.Батмөнх/-т даалгасугай.
- 3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А-282 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Д.САРАНГЭРЭЛ